

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 22 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ХОВД АЙМГИЙН “БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ” ХӨТӨЛБӨР
/2019-2022 он/

Нэг. Хөтөлбөр гаргах шаардлага, үндэслэл.

Ховд аймаг нь Монгол Алтайн нуруу, Их нууруудын хотгор, Алтайн цаад говийг хамарсан 76,0 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, далайн түвшнээс дунджаар 2230м өндөрт өргөгдсөн, эрс тэс уур амьсгалтай. Монгол Алтайн мөнх цаст уул, нурууд Мөнххайрхан, Цамбагарав, Баатарын нуруу, Хөх сэрхийн нуруу, Жаргалант хайрхан, Сутай, Мянган угалзатын нуруу, Алтан хөхий уулс далайн түвшнээс 3750-4680 м өндөрт оршдог. Малын тэжээлийн гол ач холбогдол бүхий шимт чанар сайтай 120 гаруй ургамал ургадаг. Бэлчээрийн га-ийн ургац 0,5-2,0 центнер. Хур тунадасны хэмжээ нь 120-140 мм, 1 дүгээр сарын дундаж хүйтэн -17-25,5 градус, 7 дугаар сарын дундаж дулаан +16,5 градус, салхины хурд 4,5 м/сек, хавар, намрын улирал харьцангуй урт 120-160 хоног үргэлжилнэ.

Сүүлийн 2 жилд зундаа 20-30 градус дулаан, өвөлдөө -25-30 градус хүйтэн байна.

Хөрсний бүтцийн тухайд хангай газартай харьцуулахад зузаан багатай эмзэг бор шороон хөрстэй, ургамал тачир сийрэг боловч шимт чанар сайтай. Ховд аймаг нь 5,4 сая га бэлчээрийн эдэлбэр газартай бөгөөд энэ нь аймгийн нутаг дэвсгэрийн 71,7 хувь ХАА-н эдэлбэр эзэлдэг.

Нийт бэлчээрийн 60,7 хувь буюу 3,4 сая га нь өвөл-хаврын 39,3 хувь буюу 2,0 сая га нь зун-намрын бэлчээрт ашиглагддаг.

Бэлчээрийн хангамж. Өндөр уул, их нууруудын хотгорын бүс нутгийн хонин толгой нэг малд шаардагдах бэлчээрийн багцаалсан дундаж /нэг хонин толгойд-2,66 га/ -аар тооцож үзэхэд: хонин толгойд шилжүүлснээр 5,1 сая малд 13,5 сая га бэлчээр шаардлагатай, дээрх тооцооноос манай аймгийн бэлчээрийн 5.4 сая га талбайд 2.0 сая хонин толгой мал бэлчээх чадамжтай бөгөөд одоо байгаа мал 5.1 сая хонин толгой байгаа нь бэлчээрийн хангамж 49 хувиар дутагдалтай байна.

Бэлчээрийн багтаамж даац. Шаардагдах тэжээлийн хэмжээгээр тооцвол: хонин толгойд шилжүүлснээр 5,1 сая мал 2754.0 тн өвс шаардлагатай гэсэн тооцоо гарч байна. Аймгийн бэлчээрийн дундаж ургацаар тооцоход: 1401.0 тн өвс буюу хонин толгойд шилжүүлснээр 2.6 сая малын тэжээлийн хангамжтай, 2.5 сая малд 1350.0 мянган тн тэжээл дутагдалтай байна.

Бэлчээрийн доройтлын хэмжээг сумдаар авч үзвэл:

Эрдэнэбүрэн сумын Шураг, Баянгол, Хонгио, Хар ус, Мянгад сумын Чацаргант, Цагаанбулан, Баянхошуу, Ховд сумын Дунд ус, Цагаанбургас, Чандмань сумын Сүлжээ, Манхан сумын Баянгол, Ботгон, Зэрэг гол, Дуут сумын Шивэр, Цагаанбургас, Босго, Зэрэг сумын Эхэн, Бураа, Хөндлөн, Бургасан, Дарви сумын Булаг, Булган, Мөст сумын Баянхайрхан, Хужирт, Булган сумын Баянгол, Баян судал, Буянт сумын Цагаанбургас багуудын нутагт бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн.

Эрдэнэбүрэн сумын Намарзан, Мянгад сумын Гахайт, Баянбулаг, Ховд сумын Улаан бураа, Буянт сумын Норжинхайрхан, Наранхайрхан, Нарийн гол, Чандмань сумын Баянхайрхан, Дуут сумын Хөх бэлчир, Дарви сумын Дэлгэр, Дөргөн сумын Өгөөмөр, Цэцэг сумын Баян овоо, Булган сумын Алагтолгой, Далт, Байтаг багуудын нутагт бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрсэн.

Мөн Үенч сумын Нарийн гол, Дөргөн сумын Сээр, Ховд сумын Баянбулаг, Буянт сумын Цагаан эрэг, Чандмань сумын Тахилт, Талын булаг, Урд гол, Жаргалант, Зэрэг сумын Гүвээ, Мөнххайрхан сумын Борт, Хаг, Алаг, Сэнхэр, Манхан сумын Улаан хүрээ, Мөст сумын Давст, Цэцэг гол, Цэцэг сумын Цэцэг нуур, Хажинга, Баян гол багуудын нутгаар бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрч гарсан байна.

Ийнхүү бэлчээр доройтож байгаагийн шалтгаан нь Монгол орны нутаг дэвсгэрт ажиглагдсан уур амьсгалын өөрчлөлт, ирээдүйн төсөөллөөс үзвэл өндөр уулын бүсэд агаарын температур дулаарах чиглэлээр байнга нэмэгдэж, зуны улирлын хур тунадасны хэмжээ багасаж байгаа нь хуурайшилтыг улам эрчимжүүлэн, улмаар цөлжилт, гангийн давтамж эрчмийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн бэлчээр ашиглаж ирсэн уламжлалт болон шинжлэх ухааны үндэслэлтэй менежмент алдагдан, малын чанар, ашиг шимийн ойлголтыг орхигдуулан, зөвхөн малын тооны өсөлтийг эн тэргүүнд тавьсны улмаас бэлчээрийн даац хэтэрсэн, сүргийн бүтэц алдагдсан, бэлчээрийн усан хангамж эрс муудсан, дэд бүтцийн хөгжлийн түвшингээс улбаалан төв, суурин газар, уст цэгийн орчим болон зам дагуу хүн мал ихээр төвлөрсөн, бэлчээрийг зохистой ашиглах арга туршлагатай хүмүүс ховордсон, бэлчээрийн менежментийн талаарх мэргэжилтэн, малчдын мэдлэг чадавх сул орон нутгаас бэлчээрийн ургамалжилт, түүний төлөв байдал, ашиглалтад тулгуурлан зохистой ашиглах, сайжруулах хамгаалах ажлыг удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, төрийн бодлого зохицуулалт сул, хөрөнгө санхүүжилт хүрэлцээгүй зэрэгтэй шууд холбоотой бөгөөд үүнийг даван туулах зорилтыг тусгасан урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго, тэргүүлэх чиглэл.

Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд бэлчээрийг хуваарь сэлгээтэй, зөв менежментээр урт хугацааны туршид зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах, бэлчээрийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, мал аж ахуйг шимт чанар сайтай бэлчээрийн тэжээлээр хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилт дэвшүүлэн ажиллана. Үүнд:

Зорилт 1. Бэлчээрийн менежментийг сайжруулах: Орон нутгийн газар зүй, хөрс, ургамалжилт, уур амьсгалын онцлогт тохируулан мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангахын тулд бэлчээрийг нэгдсэн аргачлалаар уян хатан төлөвлөх, зохицуулах, хамгаалах, хяналт үнэлгээ хийх, нөхөн сэргээх, сэлгэн өнжөөх,

Зорилт 2. Мал, амьтны менежмент: Бэлчээрийн бүтээмжит чанар буюу даацад нь нийцүүлсэн МАА-н үйлдвэрлэл эрхлэх, бэлчээрийн нөөцөд тохирсон мал сүргийн бүтэц, тоог бий болгох,

Зорилт 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа: “Бэлчээр” хөтөлбөрийн зорилго, стратегийн зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуй нэгж, байгууллага, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог дэмжиж өргөнөөр оролцуулах, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх,

Зорилт 4. Бэлчээр ашиглагчдыг хариуцлагажуулах журам: Бэлчээрийн нөөц чадавхад тохируулан Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулахад малчдын оролцоог хангах, идэвхжүүлэх, эрх үүргийг тодорхой болгоход эдийн засгийн хөшүүрэг бий болгох замаар МАА-н зохистой үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэлчээрийн даацаас хэтэрсэн хонин толгой тутмаас авах хураамжийн эрх зүйн зохицуулалтыг шинээр батлан гаргах бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмаар баталгаажуулан, аймгийн хэмжээнд хураамжийн дээд, доод хязгаарыг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах,

Зорилт 5. Малчдын орлогыг нэмэгдүүлэх: Бэлчээрийн даацад тохирсон мал сүргийг өсгөн үржүүлэх, бэлчээрийн даацаас илүү гарсан малыг борлуулан хадгаламж, зээлийн хоршоо байгуулах санаачилгыг дэмжих, мал сүргээ маллан үржүүлэхийн зэрэгцээ малчид газар тариалан хослуулан эрхлэх, МАА - н бус бизнес эрхлэх боломжоор хангах,

Нэгдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1.1. Бэлчээр ашиглалтын талаар тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, багийн ИНХ-аар хэлэлцүүлнэ.

1.2. Багийн ИНХ-аар батлагдсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний үндэс болно. Сумын ИТХ-аар батлагдсан төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар баталгаажуулна.

1.3. Тухайн жилд өнжөөж, чөлөөлөх бэлчээр болон отрын бүс нутгийг сумын Засаг дарга өргөн мэдүүлснээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

1.4. Сум бүр хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгааны 1:100000 хэмжээст зураг, тайланд дүн шинжилгээ хийх.

1.5. Зурган мэдээ болон тайланд тулгуурлан сум тус бүр доройтсон бэлчээрийн талбайг доройтлын зэрэг, төрлөөр нь гаргах.

1.6. Сум тус бүр өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, ашиглагдаж байгаа болон эвдэрч дарагдсан уст цэгийн газарзүйн байрлалыг GPS багажийн тусламжтайгаар нягтлан шалган тогтоож, мэдээллийн санд оруулах.

1.7. Сум тус бүрийн бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгааны зураг, тайлан нь бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалахад ашиглах үндсэн баримт тул түүний чанар, ашиглалтыг сайжруулж, төлөв байдлын үнэлгээнд тавих хяналт, оролцоог дээшлүүлэх.

1.8. Доройтсон бэлчээрт тэжээлийн ганц ба олон наст ургамал тарьж, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхийн дээр бэлчээр нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх.

1.9 Тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлж, тэжээлийн үйлдвэр байгуулах.

1.10. Малчинтай бэлчээр ашиглах гэрээ байгуулж, гэрээнд тулгуурлан сумын төлөвлөгөө, сумын төлөвлөгөөнд тулгуурлан аймгийн төлөвлөгөө хийгдэх ба энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд баг, сум, аймгаас хяналт тавьж, төлөвлөгөө, гэрээ биелүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөшүүрэг бий болгох.

1.11. Бэлчээр ашиглагч хэсэг, бүлгүүдийн өвөлжөө, хаваржааны тусгайлсан ашиглах болон нийтээр ашиглах дундын бэлчээрийн хилийг тухайн хэсэг бүлгийн хурлаар хэлэлцэн тогтоож, гар зураг үйлдэн хамтын ажиллагааны гэрээнд тусгаж баталгаажуулна.

1.12. Хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах хадланд орох хугацааг орон нутгийн түвшинд жил бүр тогтоож мөрдүүлэх.

1.13. Бэлчээрийн мэдээллийн системд тулгуурлан малын төвлөрлийг сааруулах, бэлчээрийн улирлын сэлгээ хийх зорилгоор усжуулах ажлыг зохион байгуулна.

1.14. Бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй худаг, уст цэгийг засварлах, хөв цөөрөм байгуулах замаар бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.

1.15. Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд нийцүүлэн орон нутгийн хэрэгцээ шаардлага, захиалгад тулгуурлан ашиглагдахгүй байгаа болон бага ашиглагддаг бэлчээрт усны хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, худаг гаргах, ус нөөцлөх сан байгуулна.

1.16. Гар худаг гаргах, бэлчээрийн тодорхой хэсгийг усжуулах арга ажиллагаанд малчдыг сургах.

1.17. Бэлчээр хамгаалах, нөхөн төлжүүлэх ажлыг сайн зохин байгуулсан малчдын бүлэг, малчдыг улс, аймаг сумын шагнал урамшуулалд хамруулах.

Хоёрдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2.1. Аймгийн хэмжээнд бэлчээрийн ургамалжилт, түүний төлөв байдал ашиглалтад хяналт тавих, зохицуулах зорилгоор бэлчээрийн нэгдсэн мэдээллийн систем бий болгох.

2.2. Малчин, малчдын бүлэг, нөхөрлөлд байж болох малын тоо, төрлийг бэлчээрийн ургамалжилт, түүний төлөв байдалд тулгуурлан тогтоосон бэлчээрийн даацтай нь уялдуулан гаргаж, тухайн бэлчээрт байж болох малын тооны дээд хязгаарыг тогтоож, түүнээс давуулахгүй байх эдийн засгийн хөшүүргийг бий болгох.

2.3. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг аймаг, сумын түвшинд тогтоож, шийдвэр гаргуулах, төсөл хөтөлбөрт хамруулах.

2.4. Мал сүрэг, зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнийг хянах, зэрлэг амьтдын байршлын бүсийг нарийвчлан тогтоосноор гоц халдварт өвчнөөр тайван бүс нутгийн статусыг ханган баталгаажуулах.

2.5. Малын эрүүл мэндийн үйл ажиллагааг цогц байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх, мал үржлийн ажилд ШУ-ны ололт амжилтыг нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх.

2.6. Бэлчээр ашиглалтын гэрээнд ан, амьтан хамгаалах асуудлыг тусгаж, ан амьтан өсгөн үржүүлэх таатай орчин бүрдүүлж хэрэгжүүлэх.

2.7. Аймаг, сум бүрд цаг агаарын нөхцөл хүндэрсэн үед ашиглах зориулалт бүхий өвс тэжээлийн нөөцийн сан бий болгох, ан амьтан хамгаалах, өвс тэжээлийг зохистой түвшинд хүргэх ажлыг зохион байгуулах.

2.8. Ямаан сүргийн тоо толгойг бууруулах, сүргийн зохистой бүтцийг бий болгох.

2.9. Бэлчээрт ээлтэй тэмээ, хонь өсгөх бодлогыг дэмжих, тэмээ өсгөсөн сум, малчдыг шагнах болзол гаргаж хэрэгжүүлэх.

2.10. Бэлчээрийн даац, ургац, ургамлын бүрхэц, зуншлагын буюу ургамлын ургалтын мэдээлэл, гангийн мэдээлэл, цасны мэдээлэл, зудын мэдээлэл, зудын эрсдэлийн мэдээлэл зэрэг мэдээг 130105 дугаарын гар утаснаас авч, мал маллагаа, отор нүүдлээ зохицуулах, энэ талаар гарсан ШУ – ны шинэ дэвшилтэт, технологийг сурталчлан, малчдад тогтмол хэрэглүүлж хэвшүүлэх.

Гуравдугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1. Бэлчээр ашиглалтын хэсгүүдтэй бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж уг гэрээг газрын нэгдмэл сангийн бүртгэлд оруулах замаар Бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, бэлчээр ашиглагчдыг хариуцлагажуулах чиглэлээр төр

захиргааны болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

3.2. Орон нутгийн удирдлага, мэргэжилтэн болон малчдын бэлчээрийн менежментийн талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах ажлыг аймгийн ЗДТГ, ХОХБТХ, ХХААГ хариуцан зохион байгуулах.

3.3. Сургалт сурталчилгаа, бусад үйл ажиллагааг төрийн болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийж олон нийтэд хүргэх арга хэмжээ авах.

3.4. 2019 оноос эхлэн хэрэгжиж эхэлж байгаа “Ногоон бэлчээр” туршилтын төслийг амжилттай хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн болон ТББ, малчдын бүлэг хамтран ажиллах.

3.5. “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-тай уялдуулан Алтай, Буянт, Дарви, Дөргөн, Дуут, Зэрэг, Мөст, Цэцэг, Чандмань, Жаргалант сумдын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байх.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараах зорилго, үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлнэ

4.1. Аймаг сумдын бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам батлан гаргах.

4.2. Малчин, мал бүхий иргэдэд олгогдож буй ноос, арьс ширний урамшууллын хүн амын орлогын албан татварын 10 хувийг бэлчээр сайжруулах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулах.

4.3. Мал, мах борлуулах ажлыг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

Тавдугаар зорилтын хүрээнд дараах зорилго, үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлнэ.

5.1. Бэлчээрийн даацад тохирсон мал сүргийг өсгөн үржүүлж, даацаас илүү гарсан малаа борлуулан хадгаламж зээлийн хоршоо байгуулан хуримтлал бий болгох малчдын санал санаачилгыг дэмжих.

5.2. Малчид мал маллахын зэрэгцээ газар тариалан эрхлэх болон тэжээлийн ургамал тариалах, үржлийн мал өсгөн үржүүлэх зэрэг бусад орлогоо нэмэгдүүлэх ажил эрхлэхийг дэмжих.

5.3. Чанартай түүхий эд бэлтгэн орлогоо нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний үйлдвэрүүдтэй хамтран сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.

5.4. Малчдад түшиглэсэн нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хамтарч ажиллах.

5.5. Аялал жуулчлалыг дагаад оёдол, худалдаа үйлчилгээ зэрэг ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих.

5.6. Үндэсний үйлдвэртэй хамтарч ажиллах, түүхий эдээ нийлүүлэх тухайлбал: ясны гурил гаргах, саван үйлдвэрлэх гэх мэт орон нутагт үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжих.

5.7. Орон нутагт бэлчээрт ээлтэй малчин, Эко малчин шалгаруулах тусгай болзол журам гарган мөрдөх (малчин ногоон элч, 9 алдартан).

5.8. Олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран “Жишиг малчин өрх” бий болгож үр дүнг нь тодорхойлж нэвтрүүлэх

5.9. Малчдын сүү, цагаан идээ, арьс шир, түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах нэгдсэн бодлого гаргаж, хэрэгжүүлэх.

5.10. Малын гаралтай түүхий эдийн мөшгөх тогтолцоотой бэлтгэн нийлүүлэх систем нэвтрүүлэх.

5.11. Малчдад хуримтлал бий болгох, хадлан тэжээл бэлтгэхэд хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх.

5.12. Малчдад малын ашиг шимээс гадна бизнесээр болон уламжлалт бүтээгдэхүүн хийж орлого олоход дэмжлэг үзүүлэх.

5.13. Байгалийн өгөөжийг бүртгэх малчин өрхийн данс хөтөлж, малчин хүн байгалиас хэдий хэмжээний өвс, ус ашиглаж байгаа талаар судалгаа авах, тэдний байгальд хөрөнгө оруулалт хийх хандлагыг өөрчлөх, нэмэгдүүлэх.

Гурав: “Бэлчээр ашиглалтыг сайжруулах” хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг дараах байгууллага хариуцна.

3.1.1. Төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан хөтөлбөрийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засаг орлогчоор ахлуулсан Бэлчээрийн менежментийг дэмжих ажлын хэсэг.

3.1.2. Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг холбогдох төрийн захиргааны мэргэжлийн байгууллага.

3.1.3. Хөтөлбөрийг сум, багийн түвшинд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг тухайн шатны Засаг дарга, хэрэгжүүлэх ажлыг тухайн орон нутгийн мэргэжлийн байгууллага.

3.1.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Хүнс, хөдөө аж ахуйн газар, сум бүр боловсруулж, үр дүнг жил бүр тооцож ажиллана.

Дөрөв: Гарах үр дүн

Хөтөлбөр хэрэгжсэнээр Мал аж ахуйн багийн малчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

Дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- Бэлчээрийн уламжлалт нүүдэл, сэлгээг батлагдсан менежментийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж малын тоог тодорхой хэмжээгээр бууруулснаар бэлчээрийн талхдалтыг бууруулж бэлчээрийн нөхөн сэргэлтийг хангасан байна.
- Бэлчээрийг нөхөн сэргээх, хамгаалах, сайжруулах ажлыг МАА-н багийн түвшинд хийж бэлчээрийн 20 хувийг сэргээсэн байна.
- Хадлан бэлтгэх болзол журам гаргаж, аймгийн нөөц бэлтгэх талбайтай болсон байна.
- Тэжээлийн ургамал тариалалтыг сум, багийн түвшинд жил бүр нэмэгдүүлсэн байна.
- Бэлчээрийн усан хангамжийг 15 хувиар нэмэгдүүлснээр бэлчээр ашиглалт сайжирсан байна.
- Бэлчээрийн хортонтой тэмцэж, бэлчээрийн ургамлыг тарималжуулж, бэлчээрийн талхагдлыг бууруулснаар бэлчээрийн даац 10 хувиар нэмэгдсэн байна.
- Бэлчээрийн даацад тулгуурласан чанартай мал сүрэгтэй болсноор малчдын орлого нэмэгдсэн байна.
- Бэлчээрийг хариуцлагажуулах журам хэрэгжиж хөрөнгө төвлөрүүлэн бэлчээрийг сайжруулах цогц арга хэмжээг зохион байгуулсан байна.

Тав: “Бэлчээр ашиглалтыг сайжруулах” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлэх шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн үндсэн шалгуур үзүүлэлт нь энэ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлт болон дараах үзүүлэлтээр тодорхойлогдоно:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны түвшин	Хүрэх түвшин		
			2020 он	2021 он	2022 он
Зорилт 1. Бэлчээрийн менежментийг сайжруулах: Орон нутгийн газар зүй, хөрс, ургамалжилт, уур амьсгалын онцлогт тохируулан мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангахын тулд бэлчээрийг нэгдсэн аргачлалаар уян хатан төлөвлөх зохицуулах хамгаалах, хяналт үнэлгээ хийх, нөхөн сэргээх, сэлгэн өнжөөх					
1.1. Сум бүр бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	7	-	-	-

1.2. Тухайн жилд өнжөөж, чөлөөлөх бэлчээр	мян.га	132.7	199.1	265.6	332.1	
1.3.Газар зүйн байрлалыг GPS багажийн тусламжтайгаар нягтлан шалган тогтоож, мэдээллийн санд оруулах. - Ашиглагдаж байгаа худаг - Эвдэрч дарагдсан уст цэг	тоо тоо	104 25	1272 68	1908 102	2120 170	
1.4. Тэжээлийн ургамал тариалалт: -Тариалсан талбай -Хураан авсан ургац	га цн	397 1726	480 2160	550 2475	600 2700	
1.5 Хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах: - Хадлангийн талбай - Бэлтгэсэн хадлан	га мян.тн	17958. 2 66.0	18010.0 18010.0 67.0	18060.0 18060.0 67.5	18110.0 18110.0 70.0	
Бэлчээрт гаргасан инженерийн хийцтэй худаг	тоо	11	10	10	10	
Зорилт 2. Мал, амьтны менежмент: Бэлчээрийн бүтээмжит чанар буюу даацад нь нийцүүлсэн МАА-н үйлдвэрлэл эрхлэх, бэлчээрийн нөөцөд тохирсон мал сүргийн бүтэц, тоог бий болгох.						
2.1. Жил бүрийн ургац бэлчээрийн даацыг үндэслэн тухайн сум, аймгийн хэмжээнд байж болох малын тоог тогтоох	тоо	2676.9	2676.9	2676.9	2676.9	
2.2.Оны эхний малын тоо	Бүгд	мян.тол	3146.4	3150.0	3200.0	3250.0
	Тэмээ	хувь	0.8	0.8	0.9	0.9
	Адуу	хувь	4.1	4.1	4.1	4.1
	Үхэр	хувь	6.1	6.7	7.3	8.0
	Хонь	хувь	37.1	38.0	39.0	40.0
Ямаа	хувь	51.7	50.4	48.7	47.0	
2.4.Нэг малаас авах ашиг шим: - Цэвэр, эрлийз үнээний сүү - Ноолуур - Нарийн, нарийвтар ноос - Бүдүүн, бүдүүвтэр ноос	305 хоног/ кг грамм кг кг	1769 290 3,9 1,1	2217 290 4,1 1,2	2673 300 4,4 1,3	3200 310 4,9 1,5	
Зорилт 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа: “Бэлчээр” хөтөлбөрийн зорилго, стратегийн зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуй нэгж, байгууллага, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог дэмжиж өргөнөөр оролцуулах, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.						
Зорилт 4. Бэлчээр ашиглагчдыг хариуцлагажуулах журам: Бэлчээрийн нөөц чадавхад тохируулан бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулахад малчдын оролцоог хангах, идэвхжүүлэх, эрх үүргийг тодорхой болгоход эдийн засгийн хөшүүрэг бий болгох замаар МАА-н зохистой үйлдвэрлэлийг хөгжүүлэх бэлчээрийн даацаас хэтэрсэн хонин толгой тутмаас авах хураамжийг авах эрх зүйн зохицуулалтыг шинээр батлан гаргах бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмаар баталгаажуулан, аймгийн хэмжээнд хураамжийн дээд, доод хязгаарыг ИТХ-ын хуралдааны тогтоолоор тогтоох.						
Бэлчээр ашиглалтыг сайжруулах санд хуримтлагдсан мөнгө	сая. төг	0	100.0	200.0	300.0	
Аймаг орон нутгийн төсвөөс бэлчээр сайжруулах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө	сая. төг	80.0	90.0	100.0	105.0	
Зорилт 5. Малчдын орлогыг нэмэгдүүлэх: Бэлчээрийн даацад тохирсон мал сүргийг өсгөн үржүүлэх, бэлчээрийн даацаас илүү гарсан малыг борлуулан хадгаламж, зээлийн хоршоо байгуулах санаачилгыг дэмжих, Мал сүргээ маллан үржүүлэхийн зэрэгцээ малчид газар тариалан хослуулан эрхлэх, МАА-н бус бизнес эрхлэх боломжоор хангах.						
5.1 Зах зээлд борлуулсан мал тоо	Нийт малын 10%	314.6	340.0	370.0	400.0	

үүнээс: төрөл тус бүрээр:					
- тэмээ		2.6	2.7	3.0	3.0
- адуу		13.0	14.0	15.0	16.0
- үхэр		19.0	23.0	26.0	30.0
- хонь		117.0	130.0	140.0	150.0
- ямаа		163.0	170.3	186.0	201.0
Байгуулагдсан хадгаламж, зээлийн хоршоо	тоо	2	4	6	8

Зургаа: Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Улсын болон орон нутгийн төсөв.
- Олон улсын байгууллагын хандив, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт; /Бэлчээрийн менежментийн холбоо, Дэлхийн байгаль хамгаалах сан, Мерси Кор олон улсын байгууллага, TNC олон улсын байгууллага, SECIM төсөл.
- Малчдын төвлөрүүлсэн хураамж, хөрөнгө оруулалт.
- Сумдын ОНХС, сум хөгжүүлэх сан.
- Бусад эх үүсвэр.



**ХОВД АЙМГИЙН “БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР” ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2019-2022 он)**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа (оноор)				Шаардагдах нийт төсөв	Санхүүжилтийн эх үүсвэр (сая төг)			Хүрэх үр дүн	Оролцогч талууд	
			2019	2020	2021	2022		Улсын төсөв	Орон нутгийн төсөв /аймаг/	бусад эх үүсвэр (ОУБ, төсөл хөтөлбөр, бизнес бүлэглэл гэх мэт)		Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага албан тушаалтан
Зорилт1. Бэлчээрийн менежментийг сайжруулах:													
1	Орон нутгийн газар зүй, хөрс, ургамалжилт, уур амьсгалын онцлогт тохируулан мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангахын тулд бэлчээрийг нэгдсэн аргачлалаар уян хатан төлөвлөх зохицуулах хамгаалах, хяналт үнэлгээ хийх, нөхөн сэргээх, сэлгэн өнжөөх.	1.1. Бэлчээр ашиглалтын талаар тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, багийн ИНХ-аар хэлэлцүүлнэ.									Тухайн жилд хийгдэх ажлын тоо хэмжээ, хөрөнгө оруулалтад малчид, малчдын бүлгийн санал бодитоор тусгагдана.	Багийн ИНХ, багийн ЗД	Сумын БМДАХэсэг
		1.2. Багийн ИНХ-аар батлагдсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний үндэс болно. Сумын ИТХ-аар батлагдсан төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар баталгаажуулна.								Тухайн жилийн сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээрийн менежментийн чиглэлээр хийгдэх ажил тусгагдсанаар хэрэгжих, хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэнэ.	Сумын ИНХ сум, багийн ЗД, газрын даамал, СБАХ, БМДАХэсэг	Аймгийн ЗДТГ, ХХААГ, ГХБХБГ, АБАХ, ДБХС, Мерси кор ОУБ бусад	

	<p>1.3.Сум бүр хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгааны 1:100000 хэмжээст зураг, тайланд дүн шинжилгээ хийх.</p>				30.0	10.0	10.0	10.0	<p>Бэлчээрийн газрын хянан баталгааны тайлан мэдээллийг бэлчээрийн мэдээллийн санд оруулан, бэлчээр төлөвлөлтөд бүрэн ашиглаж хэвшсэн байна.</p>	<p>Аймгийн ИТХ, ЗД, ХХААГ</p>	<p>АБАХ</p>
	<p>1.4. Сум тус бүр өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, ашиглагдаж байгаа болон эвдэрч дарагдсан уст цэгийн газарзүйн байрлалыг GPS багажийн тусламжтайгаар нягтлан шалган тогтоож, мэдээллийн санд оруулах.</p>				17.0		10.0	7.0	<p>Худгийн нэгдсэн мэдээллийн сан бий болно. Уст цэгийн хайгуулын зардал хэмнэгдэнэ. Шинээр гаргах, сэргээн засварлах худгийн тоо, байршил, хүчин чадлын үзүүлэлтийг тооцоход шаардла гатай үндсэн бааз суурь материалтай болно.</p>	<p>Сумдын ЗДТГ, БМДАХэсэг</p>	<p>Аймгийн ЗДТГ, ХХААГ, ГХБХБГ, АБАХ, ТХБ</p>
	<p>1.5. Сум тус бүрийн бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгааны зураг, тайлан нь бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалахад ашиглах үндсэн баримт тул түүний чанар, ашиглалтыг сайжруулж, төлөв байдлын үнэлгээнд тавих хяналт, оролцоог дээшлүүлэх.</p>				20.0		8.0	12.0	<p>Бэлчээрийн газрын мониторинг үнэлгээ хийгдэж, бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах менежментийг оновчтой зөв хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.</p>	<p>Сумдын ЗДТГ, БМДАХэсэг</p>	<p>Аймгийн ЗДТГ, ХХААГ, ГХБХБГ, АБАХ, ТХБ</p>

1.6. Доройтсон бэлчээр, атаршсан хадлангийн талбайг усжуулах, чулуу түүх замаар ургацыг сайжруулах тэжээлийн нэг ба олон наст ургамал тарьж, тэжээлийн нөөц, талбайг нэмэгдүүлэх					120.0	60.0	60.0	Бэлчээр, хадлангийн талбайн хэмжээ, ургац тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна.	БМДАХэсэг	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, ХХААГ, АБАХолбоо, малчид, мал бүхий иргэд, малчдын бүлэг нөхөрлөл	
1.7 Тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлж, Тэжээлийн үйлдвэр байгуулах. /Манхан, Буянт, Булган/					600.0	300.0	300.0	Үйлдвэр барьж байгуулан ашиглалтад оруулж, шинээр ажлын байр бий болж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг болсон байна.	Аймгийн Засаг дарга, ХХААГ, Манхан, Буянт, Булган сумдын Засаг дарга,	Аймгаас сонгогдсон Монгол улсын Их хурлын гишүүд, ХХААХҮЯ	
1.8. Хадлан тэжээл бэлтгэх, хадгалах технологийг сайжруулж, өвс, тэжээлийн агуулах фондыг бүсчлэн байгуулах, хуучин фондуудыг сэргээн засварлах.					326.0	226.0	50.0	50.0	5 сум, аймгийн төвд өвс, тэжээлийн агуулах фонд шинээр барьж, сэргээн засварласан байна.	Аймгийн ЗД, ЗДТГ, ХХААГ	ХХААХҮЯ, аймаг, сумын ИТХ,
1.9. 16 сумын бэлчээрийн мэдээллийн санд тулгуурлан малын төвлөрлийг сааруулах, бэлчээрийг хуваарь сэлгээтэй ашиглах ажлыг зохион байгуулна.					37.0	10.0	10.0	17.0	Тодорхой хэмжээний бэлчээрийн газрын талхлагдал багасч, ургамал сэргэн ургах нөхцөл бүрдэнэ.	ХХААГ	Сумдын ЗД, ЗДТГ
1.10. Бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, уст цэгийг засварлах, замаар бэлчээрийн усан хангамжийг сайжруулах.					560.0	160.0	200.0	200.0	Жил бүр 10-аас доошгүй инженерийн хийцтэй худаг шинээр гаргах.	ХХААГ	Сумдын ЗД, ЗДТГ

	1.11.Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд нийцүүлэн орон нутгийн санаачлагад тулгуурлан ашиглагдахгүй байгаа болон бага ашиглагддаг бэлчээрт усны хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, худаг гаргах, ус нөөцлөх сан байгуулах.					80.0	80.0			Шинээр инженерийн хийцтэй худаг гаргах уст цэгийн байршил, ерөмдөх гүн тодорхой болно.	ХХААГ	Сумдын ЗД, ЗДТГ
	1.12. Цас, борооны усыг тогтоож, хөв, цөөрөм байгуулан бэлчээрийн тодорхой хэсгийг усжуулах, услалтын систем шинээр барих, засварлах замаар тэжээлийн ургамал тариалах талбайг нэмэгдүүлэх.					836.0	800.0	36.0	40.0	400 га талбайг усжуулсан байх.	ХХААГ	ТХБ, сумдын ЗДТГ
Дүн						2626.0	1586.0	384.0	696.0			

Зорилт 2. Мал, амьтны менежмент:

2	Бэлчээрийн бүтээмжит чанар буюу даацад нь нийцүүлсэн МАА-н үйлдвэрлэл эрхлэх, бэлчээрийн нөөцөд тохирсон мал сүргийн бүтэц, тоог бий болгох.	2.1. Аймгийн хэмжээнд бэлчээрийн ургамалжилт, түүний төлөв байдал, ашиглалтад хяналт тавих, зохицуулах зорилгоор бэлчээрийн нэгдсэн мэдээллийн систем бий болгох, баяжилт хийх.				12.0			12.0	Бэлчээрийн даац, чадавхийг бодитоор тооцох, бэлчээрт үнэлгээ хийх ажилд суурь материалтай болж, бэлчээрийн газар төлөвлөлт мэргэжлийн түвшинд, талуудын оролцоог ханган шаардлагын түвшинд хийгддэг болно.	ХХААГ, АБАХ	ГХБХБГ
---	--	---	--	--	--	------	--	--	------	--	-------------	--------

	2.2. Бэлчээрийн даац ургамалжилт, түүний төлөв байдалтай нь уялдуулан тухайн бэлчээрт байж болох малын тооны дээд хязгаарыг малчид, малчдын бүлэг, нөхөрлөлөөр тогтоож, түүнээс давуулахгүй байх эдийн засгийн хөшүүргийг бий болгох.				15.0	5.0	5.0	5.0	Бэлчээрийн ачаалал, талхлагдал багасаж, малын тарга тэвээрэг сайжирч ашиг шим нэмэгдэн, малын эрсдэл даах чадвар нэмэгдсэн байна.	Сумдын ЗД, ЗДТГ, сумын БМДАХэсэг	Аймгийн ИТХ, ЗД, ХХААГ, АБАХ
	2.3 Буянт, Жаргалант, Манхан, Булган сумдад эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг аймаг, сумын түвшинд тогтоож, шийдвэр гаргуулах, төсөл хөтөлбөрт хамруулах.								Аймаг, сумын Иргэдийн хурлын шийдвэр гаргуулсан байна.	ХХААГ	Аймаг, сумын ИТХ, ЗД нар
	2.4. Нутгийн бог малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх.				90.0	30.0	30.0	30.0	Нийт малын 10-15хувийг шилмэл мал эзэлнэ.	Сумдын ЗД, Багийн Засаг дарга	ХХААГ, ТХБ
	2.5. Зэрлэг амьтдын байршил болон эрүүл мэндийн бүс тогтоох, бэлчээрийн нөөцөд тохирсон мал сүргийн бүтэц, тоог бий болгох.								Зэрлэг амьтдын байршил тогтоогдож, мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хянах боломж бүрдсэнээр халдварт өвчнөөр тайван бүс нутгийн статустай болох боломж бүрдсэн байна.	ХХААГ, ДБХС	Аймаг, сумын ИТХ, ЗД нар

<p>2.6. Аймаг, сум бүрт цаг агаарын нөхцөл хүндэрсэн үед ашиглах зориулалт бүхий өвс тэжээлийн нөөцийн сан бүрдүүлэх зорилгоор Булган, Буянт, Мянгад сумдад хадлангийн механикжсан салаа бий болгох.</p>		600.0	200.0	200.0	200.0	<p>Аймаг, сум бүрд цаг агаарын нөхцөл хүндэрсэн үед ашиглах зориулалт бүхий өвс тэжээлийн нөөцийн сан бий болж, мал, ан амьтныг хамгаалах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлснээр мал амьтны эрсдэл буурсан байна.</p>	<p>Аймгийн сумдын ХХААГ</p>	<p>ЗД, ЗД, ОБГ</p>
<p>2.7. Ямаан сүргийн тоо толгойг бууруулах, сүргийн зохистой бүтцийг бий болгох.</p>						<p>Ямаан сүргийн тоо толгойг одоогийн байгаа түвшингээс хэтрүүлэхгүй байх, цаашид үүлдэр угсааг сайжруулах замаар ашиг шимийн үзүүлэлтийг нэмэгдүүлэн, тоо толгойг жил бүр 2 %-иар бууруулах, сүргийн зохистой бүтцийг бий болгох</p>	<p>Сум, багийн ЗД</p>	<p>АБАХ, СБАХ, БАХ, малчдын бүлэг, нөхөрлөл, мал бүхий иргэд</p>
<p>2.8. Бэлчээрт ээлтэй тэмээ, хонь өсгөх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, тэмээ өсгөсөн 3 сум, 6 малчдыг шагнах болзол зарлан шалгаруулах (=3*200; 6*100)</p>		12.0	2.0	5.0	5.0	<p>Сүрэгт эзлэх, тэмээ, хонины тоо 10 %-иар нэмэгдсэн байна.</p>	<p>ХХААГ</p>	<p>Аймгийн ЗДТГ,ТХ Б</p>

		2.9. Бэлчээрийн даац, ургац, ургамлын бүрхэц, зуншлагын буюу ургамлын ургалтын мэдээлэл, гангийн мэдээлэл, цасны мэдээлэл, Зудын мэдээлэл, Зудын эрсдэлийн мэдээлэл зэрэг мэдээг 130105 дугаарын гар утаснаас авч, мал маллагаа, отор нүүдлээ зохицуулах, энэ чиглэлээр гарсан ШУ – ны шинэ дэвшил, технологийг сурталчлан, малчдад тогтмол хэрэглүүлж, хэвшүүлэх.				6.0	2.0	2.0	2.0	ШУ–ны шинэ дэвшил, технологийг 17 сумын малчдад сурталчлах, гарын авлага материалаар хангах замаар бэлчээртэй холбоотой мэдээллийг түргэн шуурхай цаг алдалгүй чадварыг эзэмшүүлсэн байна.	Мерси Монгол улсын байгууллага	Кор олон	ХХААГ
	Дүн					735.0	239.0	242.0	254.0				
Зорилт 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа:													
3	“Бэлчээр” хөтөлбөрийн зорилго, стратегийн зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуй нэгж, байгууллага, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог дэмжиж өргөнөөр оролцуулах, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.	3.1. Бэлчээр ашиглалтын хэсгүүдтэй бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж уг гэрээг газрын нэгдмэл сангийн бүртгэлд оруулах замаар бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, бэлчээр ашиглагчдыг хариуцлагажуулах чиглэлээр төр захиргааны болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана.				15.0	5.0	5.0	5.0	Сумдад бэлчээр ашиглагчдын бэлчээр сайжруулах, зохистой ашиглах талаар бэлчээр ашиглалтын гэрээ байгуулан, бэлчээр ашиглагчдыг хариуцлагажуулах чиглэлд бүх талуудын оролцоог ханган ажилласан байна.	Сумдын СБАХ, БАХ	ЗД,	ХХААГ, АБАХ
		3.2. Орон нутгийн удирдлага, мэргэжилтэн болон малчдын бэлчээрийн менежментийн талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах.				10.0	2.0	2.0	6.0	Орон нутгийн удирдлага, мэргэжилтэн болон малчдын бэлчээрийн менежментийн талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан байна.	ЗДТГ, ХОХБТХ, ХХААГ		ТХБ, сумдын ЗДТГ

		3.3. "Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-тай уялдуулан Алтай, Буянт, Дарви, Дөргөн, Дуут, Зэрэг, Мөст, Цэцэг, Чандмань сумдын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байх.				10.0	5.0	5.0	Тухайн сумдын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.	БМДАХэсэг	Сумдын ИТХ, ДБХС
Дүн					35.0	7.0	12.0	16.0			
Зорилт 4. Бэлчээр ашиглагчдыг хариуцлагажуулах журам:											
4	Бэлчээрийн нөөц чадавхад тохируулан Бэлчээр ашиглалтыг хариуцла агажуулахад малчдын оролцоог хангах, идэвхжүүлэх, эрх үүргийг тодорхой	4.1. Аймаг сумдын бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам батлан гаргах.				12.0		12.0	Журам батлагдан гарч хэрэгжилтийг ханган ажиллах, бэлчээрт малчид, орон нутгаасаа хөрөнгө оруулалт хийх боломж нөхцөл бүрдэж, хөрөнгө оруулалтын хэмжээ үлэмж нэмэгдсэн байна.	БМДАХэсэг	Аймгийн ИТХ, ДБХС, АБАХ
		4.2. Малчин, мал бүхий иргэдэд олгогдож буй ноос, арьс ширний урамшууллын хүн амын орлогын албан татварын 10 хувийг бэлчээр сайжруулах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулах эрх зүйн орчин бүрдүүлэх.				160.0	50.0	50.0	60.0	Бэлчээр сайжруулах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.	Сумдын ИТХ, ЗД, ЗДТГ

	болгоход эдийн засгийн хөшүүрэг бий болгох замаар МАА-н зохистой үйлдвэрлэлийг хөгжүүлэх бэлчээрийн даацаас хэтэрсэн нэг хонин толгой тутмаас авах хураамжийг бэлчээр ашиглалтыг хариуцл агажуулах журмаар баталгаажуулах, аймгийн хэмжээнд хураамжийн дээд, доод хязгаарыг тогтоож ИТХ-ын хуралдааны тогтоол гаргах.	4.3. Мал, мах борлуулах ажлыг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.							Малчдын орлого нэмэгдэж, бэлчээрийн даац багтаамжид тохирсон мал сүргийг өсгөн үржүүлэх боломж бүрдэнэ. Нийт мал сүргийн 10 %-ийг зах зээлд нийлүүлэх.	Сумдын ИТХ, ЗД, ЗДТГ	Аймгийн ИТХ, ЗД, ХХААГ	
Дүн					172.0	50.0	50.0	72.0				
Зорилт 5. Малчдын орлогыг нэмэгдүүлэх:												
5	Бэлчээрийн дацанд тохирсон мал сүргийг өсгөн үржүүлэх, бэлчээрийн даацаас илүү гарсан малыг борлуулан хадгаламж, зээлийн хоршоо байгуулах санаачилгыг дэмжих.	5.1 Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг борлуулж, хадгаламж зээлийн хоршоо байгуулах малчдын санал санаачилгыг дэмжих.				300.0		250.0	50.0	Малчдын хадгаламж зээлийн 3- аас доошгүй хоршоо байгуулагдсан байна.	БАХолбоо, Багийн Засаг дарга, Мерси-Кор ОУБ	ХХААГ
	хадгаламж, зээлийн хоршоо байгуулах санаачилгыг дэмжих, Мал сүргээ маллан үржүүлэхийн зэрэгцээ малчид газар тариалан хослуулан эрхлэх, МАА-н бус бизнес эрхлэх боломжоор хангах.	5.2,5.3. Чанартай түүхий эд бэлтгэн орлогоо нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний үйлдвэрүүдтэй хамтран сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.				30.0	10.0	10.0	10.0	Ноос, ноолуур, хөөвөр, торомны ноос, дэл сүүл бэлтгэн нийлүүлдэг малчдын хоршоо, үндэсний үйлдвэрүүд хамтран ажиллаж малчдын орлого нэмэгдсэн байна.	АБАХ	Арьс шир үйлдвэрлэгчдийн холбоо
		5.4. Малчдад түшиглэсэн нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хамтарч ажиллах.				20.0		10.0	10.0	Олон ястны фестиваль зохион байгуулж жуулчдыг татах.	АБАХ	Аймгийн ЗД, ХОХБТХ, ХХААГ

